



## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2023 оны 02 сарын 08 өдөр

Дугаар 55

Улаанбаатар хот

Улсын төсвийн 2023 оны хөрөнгө  
оруулалтын талаар авах зарим  
арга хэмжээний тухай

Төсвийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.14 дэх заалтыг үндэслэн  
Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтаар  
батлагдсан улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга  
байгууламжийн гүйцэтгэлийн явцтай уялдуулан төсвийн ерөнхийлөн захирагчийн  
багцын тухайн онд батлагдсан дүнд багтаан хөрөнгийн зохицуулалт хийж,  
санхүүжүүлэхийг төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгасугай.

2. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Сангийн яам  
(Б.Жавхлан)-д даалгасугай.



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД

САНГИЙН САЙД

Л.ОЮУН-ЭРДЭНЭ

Б.ЖАВХЛАН